

**НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2018 оны 06 дугаар
сарын 27-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Сонгуулийн ерөнхий хорооноос 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдөр ирүүлсэн саналыг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хороо “Нөхөн болон дахин сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг хүн амын тоог сонгуулийн нутаг дэвсгэртэй харьцуулан гаргасан сонгуулийн төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тухай бүр батална.”, 38.2.14 дэх заалтад нэмэлт болон дахин санал хураах, ээлжит, ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль явуулах зардал,” гэж заасан.


Байнгын хорооны хуралдааны үед Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат нөхөн болон дахин сонгуулийн зардлыг Засгийн газрын нөөц сангаас гаргахыг Улсын Их Хурлын тогтоолд тусгайлан заах шаардлагатай гэсэн санал гаргасан бөгөөд “Нөхөн болон дахин сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Нөхөн болон дахин сонгуулийн зардлын хэмжээг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН 42 ДУГААР ТОЙРГИЙН НӨХӨН
СОНГУУЛЬД ТЕХНИК ХЭРЭГСЭЛ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2018 оны 06 дугаар
сарын 27-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Сонгуулийн ерөнхий хорооноос 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдөр ирүүлсэн саналыг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хороо “Монгол Улсын Их Хурлын 42 дугаар тойрогт нөхөн сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлд сонгуулийн автоматжуулсан системийг сонгуульд хэрэглэх, ашиглах талаар Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хуульчилсан.


Байнгын хорооны хуралдааны үед Улсын Их Хурлын гишүүдээс санал гаргаагүй бөгөөд “Монгол Улсын Их Хурлын 42 дугаар тойрогт нөхөн сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Их Хурлын 42 дугаар тойрогт нөхөн сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Д.ЛҮНДЭЭЖАНЦАН

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН 42 ДУГААР ТОЙРОГТ НӨХӨН
СОНГУУЛЬ ТОВЛОН ЗАРЛАХ, САНАЛ АВАХ ӨДРИЙГ ТОГТООХ ТУХАЙ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2018 оны 06 дугаар
сарын 27-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Сонгуулийн ерөнхий хорооноос 2018 оны 06 дугаар сарын 18-ны өдөр ирүүлсэн саналыг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хороо “Монгол Улсын Их Хурлын 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Сонгуулийн ерөнхий хорооноос Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгуулийг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн товлон зарлах, Монгол Улсын Их Хурлын 42 дугаар тойрогт явуулах нөхөн сонгуулийн санал авах ажиллагааг 2018 оны 10 дугаар сарын 07-ны өдөр явуулахаар саналаа ирүүлсэн болно.


Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс санал гаргаагүй бөгөөд “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Д.ЛҮНДЭЭЖАНЦАН